



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/430

Булган сум


Антивирусны программын лиценз авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн VII/38 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын тамгын газарт Антивирусны программ хангамжийн лиценз нийлүүлсэн “Ий Эй Сольюшн” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Насанжаргал)-д даалгасугай.

2. Холбогдох зардал 2,925,000 (хоёр сая есөн зуун хорин таван мянга) төгрөгийг “Цахим Булган хөтөлбөр”-ийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР